

> Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр гүйцэтгэсэн онцлог ажлаас...

- ✓ “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд олон талт хамтын ажиллагаа” сэдвийн дор Үндэсний чуулган зохион байгууллаа.
- ✓ Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран Үндэсний сургагч багш бэлтгэх сургалтыг 2017 оны 4-р сард зохион байгуулан 50 сургагч багш бэлтгэж, улмаар 21 аймаг, 9 дүүргийн 609 хамтарсан багийн 4634 гишүүдийг хамруулсан сургалтуудыг зохион байгуулав.
- ✓ Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 27 дугаар тогтоолоор “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх Үндэсний хороо” байгуулагдав.
- ✓ Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 77 дугаар тогтоолоор “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг батлуулав.
- ✓ Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн цагдаагийн газартай хамтран зохион байгуулсан “Камержуулалтын аян”-ы хүрээнд 15 хороо, 102 СӨХ, 28 хөршийн хяналтын бүлэг, 108 иргэн 534.4 сая төгрөгийн үнэ бүхий 2211 камерыг суурилуулсан байна.
- ✓ “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд талуудын оролцоо” сэдэвт Чуулганыг 2017 оны 6-р сарын 29-ний өдөр зохион байгууллаа.
- ✓ Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр The Asia Foundation байгууллагатай хамтран “Хүн

худалдаалах гэмт хэргийн хохирогч төвтэй мөрдөн байцаалт, прокурорын хяналтыг сайжруулах төсөл”-ийг хэрэгжүүлж байна. Энэ төслийн хүрээнд хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагын алба хаагч, мэргэжилтэн нарт зориулсан энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга зүйн цогц сургалтын хөтөлбөр, гарын авлагыг боловсруулж сургалтыг зохион байгууллаа.

- ✓ Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага (The United Nations Migration Agency)-тай хамтран “Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэхэд хамтын ажиллагааг бэхжүүлэх нь” сэдэвт Зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулав.
- ✓ Олон улсын хөгжлийн эрх зүйн байгууллагатай хамтран “Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг тэмцэхэд хууль зүйн салбарын чадавх, уялдаа холбоог бэхжүүлэх сургалт”-ыг зохион байгуулж, аймаг, нийслэлийн хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагын 470 шүүгч, прокурор, өмгөөлөгч, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчдыг хамрууллаа.
- ✓ “Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, байгууллага, иргэдийн оролцоог сайжруулъя” сэдэвт Бүсийн зөвлөгөөнийг зохион байгуулав.
- ✓ Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газартай хамтран “Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, мэдээлэл солилцох, түүний илрүүлэлтийг сайжруулах нь” сэдэвт Баруун бүсийн зөвлөгөөнийг зохион байгууллаа.
- ✓ Хууль зүйн үндэсний хүрээлэн, Монголын Өмгөөлөгчдийн холбоотой хамтран “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх онол, практик” Олон улсын

эрдэм шинжилгээний хурлыг 2017 оны 7-р сарын 29-ний өдөр зохион байгуулсан бөгөөд БНХАУ, ОХУ-ын төлөөлөгчид ажлын арга, туршлагаа хуваалцав.

- ✓ Хууль зүйн салбараас 2017 оныг “Иргэдэд ойр, эрх зүйн үйлчилгээний жил” болгон зарласантай холбогдуулан орон нутагт гарч буй зам тээврийн гэмт хэрэг, ослыг бууруулах чиглэлээр “Орон нутгийн зам-Хөдөлгөөний соёл аян”-ыг зохион байгуулав.
- ✓ Хууль зүй, дотоод хэргийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны а/253, а/252 дугаар тушаалаар “Өсвөрийн сэргийлэгч” бүлгэмийн ажиллах журам батлагдан хэрэгжиж байна.
- ✓ “Гэр бүл хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх”, “Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх”, “Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх” зэрэг чиглэлээр Видео сурталчилгааны уралдаан зарлаж дүгнэв.
- ✓ “Хайрла-Хамгаал” Үндэсний цахим аяныг зохион байгуулсан бөгөөд тус аяны хүрээнд богино хэмжээний видео сурталчилгаануудыг хийж, олон нийтэд хүргэв. Энэ аяныг сурталчлах ажилд 32 телевиз, 280 аж ахуйн нэгж, байгууллагын 132.000 алба хаагчид оролцсон юм.

- ✓ АНУ-ын Коломбо план хөтөлбөртэй хамтран “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор уршгаас урьдчилан сэргийлэх, нийгмийн болон эрүүл мэндийн чиглэлээр сургагч багш бэлтгэх” сургалтыг зохион байгууллаа.

- ✓ Монгол улс дахь Гэмт хэргийн цагаан ном-2016, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга зүй зэрэг ном, гарын авлагыг олны хүртээл болгов.



МОНГОЛ УЛСАД ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ

☎ 51-265125

🌐 www.cccp.mn

📘 <https://www.facebook.com/CrimePreventionMongolia/>



Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газрын санаачлага, дэмжлэгээр хэвлүүлэв.



МОНГОЛ УЛСАД ГЭМТ ХЭРГЭЭС
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ
ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ

МОНГОЛ УЛСАД ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2017 ОНД ГҮЙЦЭТГЭСЭН
ОНЦЛОГ АЖЛУУД

Улаанбаатар хот
2018 он

> Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил гэж юу вэ?

“Гэмт хэргийн тухай мэдээллийг судалсны үндсэн дээр гэмт хэрэг гарч байгаа шалтгаан, нөхцлийг тогтоох, арилгах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох талаар авч хэрэгжүүлж байгаа цогцолбор арга хэмжээ”-г ойлгоно.

> Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл болон салбар зөвлөлийн чиг үүрэг

✓ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааг зохицуулах;

✓ Гэмт хэргийн байдал, түүний шалтгаан нөхцөлийн талаарх статистик мэдээг солилцох;

✓ Гэмт хэргийн нөхцөл байдалд хамтран дүн шинжилгээ хийх, шалтгаан нөхцөлийг арилгах арга хэмжээний чиглэлийг тогтоох;

✓ Яам, агентлаг, төрийн бусад байгууллага, захиргааны хяналтын албад эрхэлсэн асуудлынхаа хүрээнд гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх, холбогдох хууль, тогтоомжийг мэдээлэх, сурталчлах, сургалт зохион байгуулах үүрэгтэй.

✓ Мөн нутгийн захиргааны бүх шатны байгууллагууд харъяа нутаг дэвсгэртээ гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг нэгдсэн төлөвлөгөөтэйгээр зохион байгуулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг өөрийн төсвөөс тусгайлан төлөвлөж санхүүжүүлэх, хууль сахиулах байгууллагуудтай хамтран ажиллах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллагыг дэмжин ажиллах;

✓ Бүх шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь тухайн нутаг дэвсгэр дээр гарч байгаа гэмт хэрэг, түүний шалтгаан нөхцлийг арилгах талаар харъяа нутаг дэвсгэрт оршиж байгаа аж ахуйн нэгж, байгууллагаас зохиож байгаа ажлыг хэлэлцэн чиглэл өгч, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулан төсвөөс санхүүжүүлэх хөрөнгийн хэмжээг хянан баталж байх үүрэгтэй.

> Гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр төрөөс авч хэрэгжүүлж буй арга хэмжээ

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг хангах чиглэлээр тус хөтөлбөрийн 5.4.4-д Мөнгө угаах, хүний наймаа, хар тамхины болон цахим гэмт хэрэг зэрэг шинэ төрлийн гэмт хэргийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлэх, 5.4.8-д Төрөөс гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх бодлогын баримт бичгийг баталж, гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэхээр тус тус тусгасан.

🕒 Түүхэн товчоо

1965 он Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журмыг сахиулах ажлыг удирдах зөвлөлийг аймаг, хотын намын хорооны дэргэд анх байгуулав.

1974 он Прокурорын байгууллагын дэргэд Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл (ГХУСАЗЗ),

1987 он МАХН-ын Төв хорооны 1987 оны 11 дүгээр тогтоолоор МАХН-ын Төв хорооны дэргэд,

1993 он УИХ-ын 51 дүгээр тогтоолоор Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэд түр зөвлөл,

1993 он Засгийн газрын 153 дугаар тогтоолоор Засгийн газрын дэргэд Шадар сайдаар ахлуулсан Зохицуулах зөвлөл,

1995 он Засгийн газрын 142 дугаар тогтоол, Ерөнхий сайдын 78-р захирамжаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэргэд,

1996 он Хууль зүйн сайдад гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, бодлого зохицуулалтын ажлыг хариуцуулсантай холбогдуулан Нийгмийн дэг журмыг хангах зөвлөл, түүний Ажлын албыг Хууль зүйн яамны харъяанд шилжүүлсэн.

1997 он Монгол Улсын “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль” 5 бүлэг, 23 зүйлтэй батлагдав.

2001 он Монгол Улсын Ерөнхийлөгчийн 25 дугаар зарлигаар 30 хүний бүрэлдэхүүнтэйгээр Монгол Улсад ГХУСАЗЗ байгуулагдав,

2004 он Монгол Улсад ГХУСАЗЗ-ийн бүрэлдэхүүнийг 32 болгон өргөтгөв.

2005 он Монгол Улсын Ерөнхийлөгчийн 23 дугаар зарлигаар Монгол Улсад ГХУСАЗЗ-ийн бүрэлдэхүүнийг 35 болгон шинэчлэн батлав.

2012-2016 онд Монгол Улсад ГХУСАЗЗ-ийн Ажлын албыг татан буулгаж, Монгол Улсад ГХУСАЗЗ-ийн чиг үүргийг Хууль зүйн яам (хуучин нэрээр)-ны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт шилжүүлж байв.

> Өнөөгийн бүтэц, зохион байгуулалт

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2016 оны 134 дүгээр зарлигаар “Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталж, түүний ажлын албыг Хууль зүй, дотоод хэргийн яамны бүтцэд ажиллуулж байна.

Дарга:
ХЗДХ-ийн сайд

Дэд дарга:
ЗГХЭГ-ийн дэд дарга

Нарийн бичгийн дарга:
МУГХУСАЗЗ-ийн Ажлын албаны дарга


Гишүүд

- | | |
|-----------------------------------|--|
| 1 УДШЭТ-ийн тэргүүн | 17 ХХЕГ-ын дарга |
| 2 УЕП-ын орлогч | 18 ШШГЕГ-ын дарга |
| 3 Ерөнхий Аудиторын орлогч | 19 Гаалийн ЕГ-ын дарга |
| 4 НИТХ-ын тэргүүлэгчдийн дарга | 20 Татварын ЕГ-ын дарга |
| 5 Батлан хамгаалах дэд сайд | 21 ОБЕГ-ын дарга |
| 6 БСШУС-ын дэд сайд | 22 МХЕГ-ын дарга |
| 7 Зам, тээврийн хөгжлийн дэд сайд | 23 СХЗГ-ын дарга |
| 8 Сангийн дэд сайд | 24 ОӨУБЕГ-ын дарга |
| 9 УУХҮ-ийн дэд сайд | 25 Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга |
| 10 ХЗДХ-ийн дэд сайд | 26 МҮОНРТҮЗ-ийн НБД |
| 11 ХХААХҮ-ийн дэд сайд | 27 ХЗҮХ-ийн захирал |
| 12 ЭМ-ийн дэд сайд | 28 Монголын Ахмадын чөлөөт холбооны тэргүүн |
| 13 БОАЖЯ-ны ТНБД | 29 МЗХ-ны ерөнхийлөгч |
| 14 ХНХЯ-ны ТНБД | 30 Иргэдийг гэмт халдлагаас хамгаалах нийгэмлэгийн тэргүүн |
| 15 Тагнуулын ЕГ-ын дарга | 31 ХЭҮТ-ийн тэргүүн |
| 16 ЦЕГ-ын дарга | |

> Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах хэлбэр

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг Улсын хэмжээнд Хууль зүй, дотоод хэргийн сайд, аймаг, нийслэл, сум, дүүрэгт Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын удирдлаган дор орон тооны бус зохицуулах зөвлөл зохион байгуулан ажиллана (Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэг).

> Зохицуулах зөвлөлийн бүтэц



> Зөвлөлийн дэргэд Дэд зөвлөл болон үндэсний хороо, сангийн зөвлөл ажиллаж байна

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4-д “Тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах үүрэг бүхий дэд зөвлөлийг зохицуулах зөвлөлийн дэргэд ажиллуулж болно” гэж заасны дагуу Ажлын албаны орон тооны бус 6 дэд зөвлөлийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар байгуулан ажиллаж байна.

Үндэсний хороо	• Мансууруулах эм, сэтгэгцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх
Сангийн зөвлөл	• Архидан согтуурахтай тэмцэх
Дэд зөвлөл	• Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх • Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх • Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах • Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх • Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх • Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх

> Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх Дэд зөвлөл

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/205 тоот тушаалаар “Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” Дэд зөвлөлийг байгуулж, тус дэд зөвлөлийн гишүүдээр ГХУСАЗЗАА, БОАЖЯ, УУХҮЯ, ХХЕГ, ЦЕГ, ГЕГ, УЕПГ, МХЕГ, ШЕЗ, Нийслэлийн Байгаль орчны газар, Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар зэрэг хууль хяналт, төрийн захиргааны болон Олон улсын байгууллагууд ажиллаж байна.

Энэхүү дэд зөвлөлийн анхны хурлыг 2017 оны 9-р сард зохион байгуулсан бөгөөд 2017 оны 4-р улирал, 2018 оны 1-р улиралд тус тус хуралдаж, 2018 онд хамтарсан ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байна.